

ХӨНГӨН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ САЙДЫН ТУШААЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТ-
ГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1986 оны 4 дугаар
сарын I ны өдөр

Дугаар 72 / 52

Улаанбаатар
хот

Сүү түгээх салбар нээж ажил-
луулах тухай

Налайхын районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны хүсэлтийг
үндэслэн Хөнгөн хүнсний үйлдвэрийн яам, Улаанбаатар хотын
АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.Налайхын районд хүүхдийн сүү түгээх салбарыг 1986 оны
4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн нээн ажиллуулахыг Хүүхдийн
сүүн тэжээлийн үйлдвэр /н.Чимэд-Ойдов/-т даалгасугай.


2.Дээрх сүү түгээх салбарыг орон байр, мэргэжлийн болов-
сон хүчнээр хангаж цалинжуулах арга хэмжээ авахыг Налайхын
АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Жавзмаа/, Улаанбаатар хотын
Эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

3.Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэртэй аж ахуйн гэрээ
байгуулан Налайхад хүүхдийн сүү хүргэн машин нэгийг 1986
оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн ажиллуулахыг Хотын
тээврийг удирдах газар /н.Сэрээтэр/-т даалгасугай.

ХӨНГӨН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ САЙД


Г.НАРДАН

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА


С.МОНХАРТАЛ